



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс  
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны агаарын навигацийн үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжүүдийн сэлбэг нийлүүлэх Багц-6 ИНЕГ/УЗ/ХББ/Б-22/17 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:  
Б.Очирсүх

Техник хангалт, навигацийн үйлчилгээний  
албаны дэд дарга

Гишүүд:  
Г.Ганзориг

Техник хангалт, навигацийн үйлчилгээний  
албаны Навигацийн хэсгийн дарга

Б.Гантулга

Техник хангалт, навигацийн үйлчилгээний  
албаны Навигацийн хэсгийн ахлагч инженер

П.Сүхболд


Худалдан авах ажиллагааны хэлтсийн  
Гүйцэтгэлийн тасгийн аэродромын инженер

Д.Булган

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн  
албаны нягтлан бодогч

2. Комиссын гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулах, ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ болон техникийн тодорхойлолтод заасан шаардлагуудын дагуу шалгаж хүлээн авах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэхийг Комиссын дарга /Б.Очирсүх/-д даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН